



ЛАЙФ  
КОМПАНИ

ЖИЛИЙН ТАЙЛАН | 2017

### **Эрхэм зорилго**

Урт хугацааны, зөв хөрөнгө оруулалтын бодлогоор харилцагчдынхаа ирээдүйн санхүүгийн баталгааг бий болгоно.

### **Алсын хараа**

Салбартаа анхдагч бөгөөд тэргүүлэгч байдлаа хадгалж, дэлхийн жишигт хүрсэн тэтгэврийн сангийн тогтолцоог Монголын онцлогтой уялдуулан нутагшуулна.



#ИрээдүйгээӨмчил

## Агуулга

- |           |                                |
|-----------|--------------------------------|
| <b>7</b>  | Компанийн товч танилцуулга     |
| <b>9</b>  | Гүйцэтгэх захирлын мэндчилгээ  |
| <b>11</b> | Компанийн бүтэц                |
| <b>16</b> | 2017 оны онцлох үйл явдал      |
| <b>19</b> | Хөрөнгө оруулалт               |
| <b>25</b> | Санхүүгийн үзүүлэлт            |
| <b>29</b> | Хараат бус аудиторын тайлан    |
| <b>38</b> | Хамтран ажиллагч байгууллагууд |
| <b>39</b> | Санал болгож буй бүтээгдэхүүн  |



## Компанийн товч танилцуулга

2007 онд анхны хувийн тэтгэврийн сан  
үүсгэн байгуулагдав.



ХасБанк, ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн ажилчдын  
тэтгэврийн хуримтлалыг удирддаг байв.

2012 онд Ард Санхүүгийн Нэгдлийн  
охин компани болов.



Ард Актив ХЗХ дээр урт хугацаат хуримтлалын  
бүтээгдэхүүн гаргав.

2017 онд МТНД ХХК нэрээ сольж  
Ард Лайф болов.



Ард Санхүүгийн Нэгдлээс ₮1 тэрбум  
хөрөнгө оруулалт хийлээ.



## Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Эрхэм хүндэт харилцагчдаа, манай компанийн гаргаж буй анхны жилийн тайлан таны гарт хүрэлцэн очих өдрийн мэндийг хүргэе.

Ард Лайф компани нь 2007 онд МТНД (Монголын Тэтгэврийн Нэгдсэн Данс) нэртэйгээр байгуулагдаж, Монголд анх удаа хувийн тэтгэврийн сангийн үйлчилгээг эхлүүлсэн билээ. Тэнгэр Санхүүгийн Нэгдэл, ХасБанкны ажилчдын тэтгэврийн хуримтлалыг удирддаг сан байгаад 2012 онд бүтцийн өөрчлөлт орж, Ард Санхүүгийн Нэгдлийн хөрөнгө оруулалттай компани болсон юм.

2017 онд бид бүтээгдэхүүн үйлчилгээгээ шинэчлэн зөвхөн Ард Холдингсын ажилчдад бус бусад иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад хувийн тэтгэврийн сангийн бүтээгдэхүүнээ санал болгож эхэлснээр манай харилцагчдын тоо өнгөрсөн онд 163 хувиар өсч 870-д хүрч, нийт тэтгэврийн хуримтлалын хэмжээ 113 хувиар өссөн үзүүлэлттэй ажиллаа.

Ард Холдингсын Төлөөлөн удирдах зөвлөлөөс тэтгэврийн санг хөрөнгөжүүлж, үйл ажиллагааг нь идэвхжүүлж, олон нийтэд хүргэх

чиглэлийг өгсөнөөр тэтгэврийн сангийн өөрийн хөрөнгийн хэмжээг 1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэв.

Мөн Холдинг компанийн хамтын ажиллагааны хүрээнд Ард Даатгал компанитай хамтран зөвхөн манай сангийн харилцагчид хамрагдах нөхцөлтэй, хэт үнэтэй биш боловч боломжийн үнэлгээ бүхий эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгал, Ард Актив ХЗХ-той хамтран харилцагчдынхаа санхүүгийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор тэтгэврийн хуримтлалаа барьцаалсан зээлийн бүтээгдэхүүнүүдийг шинээр гаргалаа. Ингэснээр харилцагчид маань эрүүл мэндийн асуудал болон яаралтай санхүүгийн хэрэгцээгээ хуримтлалаасаа бус даатгал болон зээлийн үйлчилгээг түргэн шуурхай авч асуудлаа нэг дороос шийдэх боломжтой болж байгаа юм.

Хувийн тэтгэврийн сангийн үйлчилгээ Монголд төдийлөн хөгжөөгүй байгаа боловч бусад улс оронд аль хэдийн хөгжлийн дээд цэгтээ хүрч иргэд нь улсын тэтгэвэр, тэтгэмжээс гадна хувийн тэтгэврийн сан эсвэл даатгалаасаа нэмэлт орлого бүрдүүлж,

үр хүүхдүүдээсээ санхүүгийн хувьд хараат бус байж, тансаг машин хөлөглөж, дэлхийг тойрон аялах зорилго тавин амьдарч байна. Харин Монголд хувийн тэтгэврийн сан, даатгалын тухай хууль эрх зүйн орчин огт бүрдээгүйгээс гадна энэ тухай ойлголт, мэдлэгтэй иргэд тун хомс байгаа юм.

Монгол Улсын тэтгэврийн даатгалын сангийн алдагдал жил бүр нэмэгдэж, энэхүү алдагдлыг улсын төсвөөс санхүүжүүлсэн хэвээр. Ажил хөдөлмөр эрхэлж буй нийгмийн даатгал төлөгч иргэд төрийн алдаатай бодлого, буруу системийн улмаас ирээдүйн баталгаагаа алдаж байна.

Эв нэгдлийн санааны гэх энэхүү системийг өөрчилж, тэтгэврийн даатгалын санд хуримтлагдаж буй дүнг зөв удирдаж, хөрөнгө оруулалт хийж, сангийн хөрөнгийг нэмэгдүүлэхгүй

бол ирээдүйд улс орны хувьд тэтгэвэр олгох, иргэдийн хувьд тэтгэврийн орлогоороо амьжиргаагаа бүрэн хангахад хүндрэлтэй болно.

Мөн хувийн тэтгэврийн сан, даатгалын тухай хуулийг нэн даруй боловсруулж, иргэд зөвхөн улсын тэтгэврийн даатгалаас гадна хувийн тэтгэврийн сан, даатгалд хамрагдах нэмэлт боломжийг бий болгох шаардлагатай байна. Гэхдээ шаардлагатай гээд гадны улс орны Монголд тохирохгүй нөхцөлтэй хуулийг шууд хуулбарлан батлах биш, Монголд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулан арвин туршлага хуримтлуулсан манай баг болон бусад хувийн хэвслүүдтэй хамтран ажиллаж, хариуцлагатай ажлын хэсгийг байгуулан цогц систем бий болгох хэрэгтэй. Бид үүний төлөө хэзээд хамтран ажиллахад бэлэн байх болно.

Хүндэтгэсэн,

Гүйцэтгэх захирал



Ц.Должин

## Компанийн бүтэц






## Бар



**Б.Золбоо**  
Гүйцэтгэх захирал  
Ард Менежмент



**Г.Энхсаруул**  
Нягтлан бодогч  
Ард Лайф



**Ч.Эрдэнэ-Очир**  
Маркетинг менежер  
Ард Лайф



## Төлөөлөн удирдах зөвлөл



**Ч.Ганхуяг**  
Гүйцэтгэх захирал  
Ард Санхүүгийн  
Нэгдэл ХК



**Б.Ганбат**  
Гүйцэтгэх захирал  
Техник Технологийн  
Дээд Сургууль



**Б.Баттулга**  
Стратеги төлөвлөлтийн  
газрын дарга  
Монгол Шуудан ХК




**А.Батболд**  
Үйл ажиллагаа  
хариуцсан захирал  
Ард Даатгал ХХК



**А.Азбаяр**  
Бизнес хөгжил  
хариуцсан захирал  
Спэйшлайзд Карьер  
Консалтинг ХХК

## 2017 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ







## Хөрөнгө оруулалт

### Хөрөнгө оруулалтын философи

Хувьцаа эзэмшигчид болон харилцагчдын хөрөнгө оруулалтын багцыг урт хугацаанд, эрсдэл багатайгаар удирдаж, өгөөжийн хэмжээг боломжит өндөр түвшинд хүргэхэд зорино.

Хөрөнгө оруулалтын багцыг нэг төрлийн хэрэгслүүдээс бүрдүүлэх бус эрсдэлээ харилцан бууруулах боломжтой хэрэгслүүдэд хөрөнгө оруулна.

### Хөрөнгийн баталгаат байдал

Олон улсын стандартын дагуу хөрөнгө оруулалтаа кастодиан банканд хадгалуулах шаардлагыг хангаж, Голомт кастодиан банктай хамтран ажиллах гэрээ байгуулж, хараат бус гуравдагч байгууллагаар хөрөнгө оруулалтаа баталгаажуулж байна.

Мөн Ард Лайфын харилцагчдын хөрөнгө оруулалт манай хувь нийлүүлсэн хөрөнгөөр баталгаажиж байна.






Монгол Шуудан ХК-ийн ажилчид тэтгэврийн санд  
хамрагдаж эхэллээ.

## Улсын тэтгэврийн даатгалын сан

Нийт орлого

**1,314 тэрбум**



Нийт зардал

**1,786 тэрбум**

# ₮512 тэрбум

Тухайн жилийн алдагдал



Монголчуудын дундаж наслалт

# ₮306 мянга

Дундаж тэтгэврийн орлого

\*2016 оны байдлаар



**ARD** АКТИВ  
ХЗХ

**ARD** ЛАЙФ  
КОМПАНИ

ТЭТГЭВРИЙН ХУРИМТЛАЛЫН


**80%**

БАРЬЦААЛАН ЗЭЭЛ АВААРАЙ.

## Хувийн тэтгэврийн сангийн давуу тал



Таны хуримтлал тохиролцсон тогтмол өгөөжөөр өснө.



Хөрөнгө оруулалтын өгөөжөөр өсөх боломжтой.



Сар бүрийн тэтгэврийн хэмжээг өөрөө тогтооно.



Тэтгэвэрт гарах хугацаагаа өөрөө тодорхойлно.



Эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд хамрагдах боломжтой.




Өвлүүлэх боломжтой.




## Санхүүгийн үзүүлэлт


Нийт хөрөнгө (сая төгрөгөөр)




Богино хугацаат хөрөнгө оруулалт (сая төгрөгөөр)




**Урт хугацаат хөрөнгө оруулалт (сая төгрөгөөр)**




**Тэтгэврийн хуримтлал (сая төгрөгөөр)**



**Хөрөнгө оруулалтын өгөөж (сая төгрөгөөр)**



**Хувь нийлүүлсэн хөрөнгө (сая төгрөгөөр)**





## Хараат бус аудиторын тайлан

### “АРД ЛАЙФ” ХХК -ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

#### Санал дүгнэлт

Бид 2017 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Ард Лайф” ХХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “Ард Лайф” ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудиторын санал дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж үзэж байна.

### **Аудитын гол асуудлууд**

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их анхаарал татсан асуудал байдаг. Харин бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

### **Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага**

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

### **Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага**

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдал дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт бид

анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.

· Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээллэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

### Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчид зориулан бэлтгэсэн ба бид тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



2018 ОНЫ 03 ДУГААР  
САРЫН 16-НЫ ӨДӨР

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2017 оны 12-р сарын 31-ний өдөр

	(мянган төгрөгөөр)	
Үзүүлэлт	2017.12.31	2016.12.31
<b>ХӨРӨНГӨ</b>		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	14,061.8	47,127.4
Дансны авлага	11,655.6	28,830.0
Татвар, шимтгэлийн авлага	-	-
Богино хугацаат хөрөнгө оруулалт	3,715,752.8	2,750,294.0
Урьдчилж төлсөн зардал	16,513.0	200.7
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>3,757,983.2</b>	<b>2,826,452.1</b>
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө (цэвэр)	50.0	-
Биет бус хөрөнгө (цэвэр)	3,000.0	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,620,811.0	1,212,118.3
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1,623,861.0</b>	<b>1,212,118.3</b>
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>5,381,844.2</b>	<b>4,038,570.4</b>

Үзүүлэлт	2017.12.31	2016.12.31
<b>ӨР ТӨЛБӨР</b>		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	4,180,762.6	3,818,616.0
Цалингийн өглөг		
Бусад өглөг		
Татвар шимтгэлийн өглөг	18.9	520.4
Урьдчилж орсон орлого		1,130.0
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>4,180,781.5</b>	<b>3,820,266.4</b>
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл		
Хойшлогдсон татварын өр	39,722.3	26,541.0
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>39,722.3</b>	<b>26,541.0</b>
<b>Нийт өр төлбөр</b>	<b>4,220,503.8</b>	<b>3,846,807.4</b>
Өөрийн хөрөнгө		
Энгийн хувьцаа	1,010,000.0	10,000.0
Нэмж төлөгдсөн капитал		
Хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөц	339,400.4	-
Хуримтлагдсан үр дүн	(188,060.0)	181,763.0
<b>Нийт өөрийн хөрөнгө</b>	<b>1,161,340.4</b>	<b>191,763.0</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>5,381,844.2</b>	<b>4,038,570.4</b>

**ОРЛОГО ҮР ДҮН БОЛОН  
БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**  
2017 оны 12-р сарын 31-ний өдөр

	(мянган төгрөгөөр)	
Үзүүлэлт	2017.12.31	2016.12.31
Борлуулалтын орлого	-	-
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
Нийт ашиг	-	-
Бусад орлого	3,438.9	222.0
Ерөнхий удирдлагын зардал	(126,138.4)	(35,027.0)
Санхүүгийн орлого / ( зардал )	(24,233.5)	4,846.0
Бусад олз / (гарз)		246,088.0
<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(146,933.0)</b>	<b>216,129.0</b>
Орлогын албан татварын зардал	(329.7)	(452.0)
<b>Тайлант жилийн татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(147,262.7)</b>	<b>215,677.0</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
Хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөц	-	-
Бусад дэлгэрэнгүй орлогын хойшлогдсон татварын зардал	261,610.0	(24,609.0)
Тайлангийн хугацаанд борлуулж бодитоор хэрэгжсэн олз		
<b>Бусад дэлгэрэнгүй орлогын дүн</b>	<b>114,347.3</b>	<b>191,068.0</b>

**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН****2017 оны 12-р сарын 31-ний өдөр**

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт
<b>2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>10,000.0</b>	<b>-</b>	<b>(9,698.5)</b>	<b>301.5</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа			(707.6)	(707.6)
Залруулагдсан үлдэгдэл	10,000.0	-	(10,406.1)	(406.1)
НББ-ийн алдааны залруулга				-
Гаргасан хувьцаа	-			
Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)			191,069.0	191,069.0
Бодит үнэн цэнийн тохируулгын нөөцийн өсөлт, (бууралт)				-
<b>2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>10,000.0</b>	<b>-</b>	<b>180,662.9</b>	<b>190,662.9</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа				-
Залруулагдсан үлдэгдэл	10,000.0	-	180,662.9	190,662.9
НББ-ийн алдааны залруулга			(143,669.8)	(143,689.5)
Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)			(147,243.0)	(147,243.0)
Бодит үнэн цэнийн тохируулгын нөөцийн өсөлт, (бууралт)			261,610.0	261,610.0
Хувьцаат капиталын өсөлт, бууралт	1,000,000.0			1,000,000.0
<b>2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>1,010,000.0</b>	<b>-</b>	<b>151,340.4</b>	<b>1,161,340.4</b>

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2017 оны 12-р сарын 31-ний өдөр

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2017.12.31	2016.12.31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
Татварын өмнөх ашиг (алдагдал)	(146,933.0)	216,129.0
Тохируулга:		
Бодит үнэ цэнийн тохируулга	(13,800.5)	(246,088.0)
Хүүний авлагын өсөлт, бууралт	(3,270.0)	(371.0)
Худалдааны болон бусад авлагын бууралт (өсөлт)	36,596.4	(28,030.0)
Худалдааны болон бусад өглөгийн бууралт (өсөлт)	211,762.0	(162,190.0)
Урьдчилж төлсөн зардлын бууралт (өсөлт)	4,156.6	
Үндсэн үйл ажиллагаанаас орсон бэлэн мөнгө	88,511.5	(220,550.0)
Төлсөн хүүний төлбөр	-	-
Төлсөн татвар	(501.5)	-
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>88,010.0</b>	<b>(220,550.0)</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
Худалдаж авсан охин компани		(3,000.0)
Худалдаж авсан хөрөнгө оруулалт	(169,423.3)	(129,751.6)
Худалдсан хөрөнгө оруулалт	48,407.7	
Худалдаж авсан үндсэн хөрөнгө, ББХ	(60.0)	
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(121,075.6)</b>	<b>(132,751.6)</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
Эргэлтэнд гаргасан хувьцаа	-	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(33,065.6)</b>	<b>(353,301.6)</b>
<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>47,127.4</b>	<b>400,429.0</b>
<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>14,061.8</b>	<b>47,127.4</b>

## Хамтран ажиллагч байгууллагууд



## Санал болгож буй бүтээгдэхүүн

**Танд дараах тэтгэврийн хуримтлалын бүтээгдэхүүнийг санал болгож байна.**

1. 100% хуримтлалын буюу жилийн 12%-15.2%-ийн нийлмэл аргаар тооцогдох тогтмол хүү авах нөхцөл бүхий бүтээгдэхүүн
2. 100% хөрөнгө оруулалтын буюу тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын өгөөжөөр өсөх нөхцөлтэй бүтээгдэхүүн
3. 50% хуримтлал+50% хөрөнгө оруулалтын буюу таны хуримтлалын 50% нь тогтмол өгөөжөөр, 50% нь хөрөнгө оруулалтын өгөөжөөр өсөх нөхцөлтэй бүтээгдэхүүн

*\*Тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын өгөөж нь тухайн жилийн гүйцэтгэлд тулгуурлах учраас жил бүр өөр, өөр байна.*

Мөн та дээрх бүтээгдэхүүнүүдтэй хослуулан жилийн ₮70,000-₮280,000-ийн даатгалын хураамж төлж, ₮2 сая-₮8 сая үнэлгээ бүхий эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд хамрагдах боломжтой.

### Үндсэн нөхцөлүүд:

- Тэтгэврийн хуримтлал үүсгэх хугацаа: 5 жилээс тэтгэврийн насанд хүртэл
- Тэтгэврийн хуримтлалын доод хэмжээ: Сар бүр ₮30,000 ба түүнээс дээш
- Тэтгэвэр авах хугацаа: Хамгийн багадаа 5 жил
- Тэтгэврийн хэмжээ: Хугацааны эцэст хуримталсан нийт дүнгээс хамааран сар бүр авах тэтгэврийн хэмжээг тогтооно.  
Нийт хуримтлалын 50% хүртэлх дүнг бөөн дүнгээр авах боломжтой.

Танд санхүүгийн яаралтай хэрэгцээ гарсан тохиолдолд хуримтлалаа барьцаалан зээл авах боломжтой.

## Хувь хүмүүст санал болгож буй бүтээгдэхүүн



### Баталгаат өгөөж

Эхний жил	12%
2 дахь жил	13%
3 дахь жил	14%
4 дэх жил	14.6%
5 дахь жил	15.2%



### Хөрөнгө оруулалтын өгөөж

Тухайн жилийн хөрөнгө оруулалтын өгөөжөөс хамаарна.



### Эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгал

\*Та өөрийн сонголтоор

#### Даатгалын үнэлгээ

₮2 сая

₮4 сая

₮8 сая

#### Жилийн хураамж

₮70,000

₮140,000

₮280,000

100% хуримтлалын бүтээгдэхүүний жишээ:



Нийт төлөх хугацаа  
**30 ЖИЛ**



Сар бүр төлөх дүн  
**₮70,000**




Нийт хуримтлал  
**₮247.1 сая**



Сарын тэтгэвэр  
**₮2.1 сая**

## Байгууллага, хамт олонд санал болгож буй бүтээгдэхүүн



Ажил олгогчтой хамтарсан хуримтлалын жишээ:

	Байгууллагаас хуримтлуулсан дүн	Нийт хуримтлал	Ажилтнаас хуримтлуулсан дүн
5 жил	₮2.1 сая	<b>₮5.8 сая</b>	₮2.1 сая
20 жил	₮8.4 сая	<b>₮69.9 сая</b>	₮8.4 сая
30 жил	₮12.6 сая	<b>₮247.1 сая</b>	₮12.6 сая

## Үүсэх давуу тал



### Ажил олгогчид

- Хүний нөөцийн үр ашигтай урамшууллын систем
- Үнэ цэнтэй ажилчдаа тогтвортой ажиллуулах хөшүүрэг
- Бага зардлаар бүх ажиллагсдынхаа санхүүгийн асуудлыг шийдэх гаргалгаа
- Татвараас чөлөөлөгдөх зардал
- Ажилтны хариуцлагын сан
- Нийгмийн хариуцлагаа биелүүлэх хамгийн зөв арга



### Ажилтанд

- Таатай нөхцөл бүхий ажлын байр
- Ирээдүйн баталгаа нэмэгдэж, тэтгэврийн нэмэлт орлоготой болно.
- Хуримтлалын үлдэгдэлд өгөөж тооцогдоно.
- Тэтгэврийн төлбөртөө татварын хөнгөлөлт эдлэх боломжтой
- Тэтгэврийн сангийн үлдэгдлээ өвлүүлэх боломжтой
- Амьдрал, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг хослуулан авах боломжтой

# ARD САНХҮҮГИЙН НЭГДЭЛ



Ердийн даатгал



Банк бус санхүүгийн  
байгууллага



Брокер, диллер, андеррайтер  
хөрөнгө оруулалтын зөвлөх



Тэтгэврийн сан



Хадгаламж зээлийн  
хоршоо



Хөрөнгө оруулалтын  
менежмент



Хөрөнгө оруулалтын сан



Криптовалютын арилжаа



Санхүүгийн сургалт



Шуудангийн цогц  
шийдэл



Санхүүгийн програм хангамж



Үл хөдлөх хөрөнгийн  
түрээс

